



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/24

Улаан-Уул

“Хүний хөгжлийг дэмжих” жилийн
ажлын төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 05/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :


1. “Хүний хөгжлийг дэмжих” жилийн ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар идэвх санаачлага гарган ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, улирал тутам Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Зоригт)-д даалгасугай.

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАТ

642201011



“ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Санхүүгийн эх үүсвэр	Хүрэх түвшин	Хариуцах эзэн хамтран зохион байгуулах байгууллага
1	2	3	4	5	6	7
1	Сумын нийт өрх, хүн амын талаарх нийгэм, эдийн засгийн суурь судалгааг гаргах, судалгаанд үндэслэн бодлого, шийдвэрийг боловсруулах	-Шаардлагатай судалгааг гаргаж улирал тутам шинэчилсэн байна. -Судалгаанд тулгуурласан бодлого төлөвлөлтийг боловсруулсан байна.	Өрх хүн амын суурь судалгааг 2021 онд гаргасан.	Төсөв шаардлагагүй	Судалгааны үнэн зөв бодит байдал сайжирч үйлчилгээний чанар үр дүн дээшилнэ.	Баг, байгууллагуудын дарга эрхлэгчид, Удирдлагын баг
2	Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт их эмч, бага эмчийг батлагдсан бүтэц, орон тоогоор ажиллуулах, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	-Эрүүл мэндийн төвд 1 их эмч, багуудыг бага эмчээр бүрэн хангасан байна. -ЕБС-ийг эмчтэй болгосноор	Тогтвор суурьшилтай ажиллах эмч эмнэлгийн мэргэжилтний хүрэлцээ хангамж муу байна.	Тухайн байгууллагын төсвөөс	Эмч мэргэжилтнүүд бүтэц орон тоогоор ажилласнаар эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	Сумын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, Сургуулийн захирал
3	Иргэдийн дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах. Шаардлагатай иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	-15-65 хүртэлх насны иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулсан байна -Өвчлөлийн талаарх судалгаатай болсон байна.	Амбулаторийн үзлэгээр оношлож байгаа ба нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж байгаагүй.	Орон нутгийн хөгжлийн сан, бусад төсөл хөтөлбөр	15-с дээш насны орон нутагт амьдарч буй 1648 иргэнийг бүрэн хамруулж, нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай иргэдийн судалгаатай болсон байна.	Сумын Засаг дарга, ЭМТ-ийн дарга

2.

1	2	3	4	5	6	7
4	Эрүүл зөв хоолыг хэрхэн бэлдэх арга аргачлал, эрүүл хүнсний талаарх мэдээлэл, сургалтыг гэр бүл, хөршийн дунд зохион байгуулах	- "Эрүүл хоол" хоолны үзэсгэлэн гаргаснаар - 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулснаар	Энэ төрлийн ажил, арга хэмжээ зөвхөн ЭМТ, СӨБ-ын хэмжээнд зохиогдож байсан.	Эрүүл мэндийн боловсрол олгох төсөл хөтөлбөрөөс	Эрүүл зөв хооллолтын талаарх мэдлэгтэй иргэдийн тоо нэмэгдэнэ.	Эрүүл мэндийн төв, Багийн Засаг дарга нар, Гал тогоо бүхий төсөвт байгууллагууд
5	Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, шүдний өвчлөлийг бууруулах, эрүүлжүүлэх.	-2-18 насны хүүхдүүдийг бүрэн хамруулснаар -Мэргэжлийн эмчтэй хамтран ажиллах гэрээ байгуулснаар	ЕБС, цэцэрлэгийн хүүхдүүдийн 80% шүдний өвчлөлтэй байна.	Орон нутгийн хөгжлийн сан, бусад төсөл хөтөлбөр	Хүүхдүүдийн амны хөндийн өвчлөл 50% хүртэл буурсан байна.	Сумын Засаг дарга, Эрүүл мэндийн дарга
6	Фитнессийн төв байгуулах	-Хуучин соёлын төвд их засварын ажил хийснээр -Цаашид үйл ажиллагаа тогтвортой болсноор -Хамрагдсан, үйлчилгээ авсан хүний тоогоор	Ашиглах тоног төхөөрөмжийн нөөцтэй.	Бусад эх үүсвэр	Иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, эрүүл мэндийн боловсрол олгох, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд ахиц дэвшил гарч, 100 иргэн үйлчилгээ авсан байна.	Ажлын хэсэг
7	Үндэсний хөгжим, уртын дуу, бүжиг, уран уншлага, язгуур урлаг, спортын олон төрлөөр сургалт зохион байгуулах.	-Морин хуур, уртын дуу, уран уншлага, язгуур урлагийн сургалтад 200-гаас доошгүй иргэнийг хамруулснаар -Бүжиг, спортын төрөлд нийт 500-с доошгүй иргэнийг хамруулснаар	Зарим төрлийн дугуйлан хичээллэж байгаа ч иргэдийн идэвх оролцоо хангалтгүй байна.	Байгууллагуу дын төсвөөр	Иргэдийн авьяасыг нээн хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлсэн байна.	Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирлууд
8	Нийтийг хамарсан урлаг спортын уралдаан, тэмцээнийг тоог нэмэгдүүлэх, тогтмолжуулах.	-Шатарчин хөдөлгөөн өрнүүлснээр -Үндэсний бөхийн барилдааныг улирал тутам зохион байгуулснаар -Шинэ тутам арга хэмжээг 10-с доошгүйг зохион байгуулснаар	Дэлхий нийтийг хамарсан ковид цар тахлын үед энэ төрлийн арга хэмжээ зохион байгуулагдаагүй.	Бусад эх үүсвэр	Үйл ажиллагаа тогтмолжиж, нийт хүн амын 70-с доошгүй хувь хамрагдсан байна.	Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирлууд, Хөрш айлын ахлагч нар

1	2	3	4	5	6	7
9	Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжсэн клубуудыг байгуулах, түүгээр дамжуулан иргэдийн дунд "Ур чадвар авьяасаа өвлүүлье-Гэрийн багш-Гарын шавь" уралдаан зарлах	-Хүүхдийн хөгжлийг дэмжсэн 5 с доошгүй оролцооны клуб шинээр байгуулагдана. -Гэр бүлийн чиглэлээр 2-с доошгүй клуб байгуулагдсанаар /Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй ээжүүдийн клуб, эмээ өвөөгийн клуб, аавуудын клуб болон бусад сонирхлын клуб .. гэх мэт / -Уралдааны удирдамж гаргаж, дүгнэснээр	Хүүхдийн Өөрөө удирдлагын 9 клуб, дугуйлан ажиллаж байна.	Бусад эх үүсвэр	Клубуудын үйл ажиллагаа тогтмолжиж, хөгжих орчин бий болно.	Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирлууд, Хөрш айлын ахлагч нар
10	Иргэдийн эдийн засаг, санхүүгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, өрхийн орлого зарлагыг зөв удирдах чадавхад сургах	-Задгай мөнгө цуглуулах уралдааныг ЕБС-ын сурагчдын дунд зохион байгуулсан байна. -Холбогдох санхүүгийн байгууллагуудтай хамтран "Хуримтлалтай Өлзийтчүүд" сургалт зохион байгуулсан байна.	Иргэдийн эдийн засаг, санхүүгийн мэдлэг боловсрол муу	Бусад эх үүсвэр	ЕБС-ын сурагчид хуримтлал үүсгэх, хуримтлалын ашиг шимийн талаар ойлголттой болохын зэрэгцээ иргэд санхүүгийн мэдлэгээ болсноор өрхийн эдийн засгийг зөв удирдаж чадавхтай болсон байна.	Засаг даргын Тамгын газар, Хөрш айлын ахлагч нар
11	Нийгмийн тулгамдсан асуудлыг оношлох, шийдвэрлэх, оролцогч талууд, зориолтот бүлгийн иргэдийн чадавхжуулах сургалтыг явуулах багтай болох	-Сургалтыг багийг сонгон шалгаруулснаар -Сургалт зохион байгуулахад үзүүлсэн санхүүгийн дэмжлэгээр -Залуу гэр бүл, эмэгтэйчүүд, төрийн албан хаагч, малчид, эцэг эхчүүд, архины хамааралтай гэр бүл, эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд чиглэсэн сургалтын тоогоор	Сургалтын баг байхгүй	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас	Хүн амын бүлгийн 60 хувьд хүрч үйлчилгээ үзүүлнэ. /2300/ Гэр бүл, иргэн бүрийн дагаж мөрдөх эрхэмлэх зүйлтэй болсон байна.	Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирлууд, Хөрш айлын ахлагч нар, Сургалтын баг, Насан туршийн боловсрол.

4.

1	2	3	4	5	6	7
12	Хөрш-Айлын үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бүтээлч ажил арга хэмжээг олон талт хэлбэрээр зохион байгуулах.	-Хөрш айлын журамд нэмэлт өөрчлөлт оруулснаар -"Хөрш айл"-д суурь судалгаа, шинжилгээ хийснээр -Удирдамж гаргаж, уралдаан зарласнаар	71 хөрш айл байгуулагдсан.	ОН-ийн төсөв	Сумын хөгжил дэвшилд оролцох иргэдийн оролцоо сайжирч хамтач байдлыг эрхэмлэсэн Хөрш Айлууд бий болно.	Нийгмийн бодлогын ажилтан Удирдлагын багийн ахлагч нар
13	"Эртэч Өлзийтчүүд" аян зохион байгуулах	-Өглөөний гүйлт, алхалт арга хэмжээг тогтмолжуулснаар -Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа эхлэхээс өмнө Төрт ёсоо дээдэлж, хүндлэх соёлыг бий болгосноор	Нарны алхалт арга хэмжээ зохион байгуулагдаж байсан нь зогссон.	Төсөв шаардлагагүй	Эртэч Өлзийтчүүд арга хэмжээний тоо, иргэдийн хамрагдалт нэмэгдэж үйл ажиллагаа тогтворжиж, сумын төвд амьдарч байгаа 700 иргэн хамрагдсан байна.	Ажлын хэсэг Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирлууд, Хөрш айлын ахлагч нар
14	"Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх.	-Хог хаягдлыг ангилах, ачих, дамжуулах бүтэц бий болсноор - айл өрх, албан байгууллага аж ахуйн нэгж бүр зориулалтын хогийн савтай болсноор -Даавуун тор хэрэглэж хэвшсэнээр - Энэ чиглэлээр хамтран ажиллах сонирхолын клуб, хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх	Хог хаягдлыг ангилах чиглэлээр хүүхдийн Тэмүүлэл клубийн санал санаачилга гарсан	Орон нутгийн төсөв	Хог хаягдлыг ангилах, тээвэрлэх, борлуулах зохион байгуулалтын бүтэц бий болно. Гялгар торыг худалдаанд хэрэглэхгүй байх соёлыг төлөвшүүлнэ.	Багийн Засаг дарга, Байгаль орчны байцаагч
15	"Жорлонгоо өөрчилъё" хөдөлгөөн өрнүүлэх	-Нийт айл өрхийг стандарт шаардлага хангасан нүхэн жорлонтой болгох -ШТС, Цагдаагийн Пост, аялал жуулчлалын газруудыг албан шаардлага хүргүүлж эко 00-той болгосноор	Тодорхой ажил хийгдээгүй.	Орон нутгийн төсөв	Байгальд ээлтэй жорлонтой өрх, аж ахуйн нэгж байгууллагын тоо нэмэгдэнэ.	Багийн Засаг дарга нар, Байгаль орчны байцаагч

5.

1	2	3	4	5	6	7
16	"Урлаг спортын бага наадам" зохион байгуулах	-Хөрш айл, баг, сумын түвшинд урлаг спортын наадмыг үе шаттайгаар зохион байгуулснаар -Хөдөөгийн багуудын малчин өрх, хүн амд урлаг соёл, номын сангийн явуулын үйлчилгээгээр үйлчилснээр	2017 онд урлаг спортын бага наадам зохион байгуулж байсан	Байгууллага, орон нутгийн төсөв -4,0 сая	Бага наадам зохион байгуулагдаж, иргэдийг олон нийтийн болон соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд оролцох идэвх, оролцоог нэмэгдүүлж нийт хүн амын 80 хүртэл хувийг хамруулсан байна.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Багийн Засаг дарга, Тамгын газар, Соёлын төв
17	Угийн бичиг хөтлөлтийг сум, багийн түвшинд эрчимжүүлэн идэвхжүүлэх, угийн бичгийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах	-Төсөвт байгууллагын албан хаагчдын 50 хувь угийн бичиг хөтөлсөн байна. -Нийт өрх, хүн амд угийн бичиг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулж, угийн бичиг хөтлөлтийн түвшин одоогийн түвшингээс 30-хувиар нэмэгдүүлсэн байна.	2021 оны байдлаар 150 өрх хөтөлсөн дүн мэдээтэй.	Төсөв шаардлагагүй	Удмын санг эрүүл байлгах, цус ойртолтоос сэргийлэх, иргэдийн угийн бичгийн талаарх мэдлэг ойлголт дээшилж угийн бичиг хөтлөлт тодорхой хувиар нэмэгдэнэ	Сургуулийн нийгмийн ажилтан, Албан бус боловсролын төв, сум сургуулийн номын санч, Засаг даргын Тамгын газрын нийгмийн ажилтан, сумын угийн бичгийн холбоо
18	"Өрх бүр үйлдвэрлэгч" аяныг өрнүүлж энэ хүрээнд "Хөрш айл", малчин өрх, иргэдийн дунд МАА-н түүхий эдээр уламжлалт бүтээгдэхүүн хийх, ашиглах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх	-Мал аж ахуйн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингэж уламжлалт бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж, өрхийн орлого нэмэгдсэн байна - Брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулж, дүгнэж, шагнаж урамшуулна. -"Хөрш айл", малчин өрхүүдийн дунд Эко хүнс аян өрнүүлнэ. -"Малчин заяа" нэвтрүүлгийг хийж, цуврал 9 нэвтрүүлгийг олны хүртээл болгосон байна. - Сумд ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр үндэслэл тооцоололтой хийгдсэн зах зээлийн	Мал аж ахуйн түүхий эдийн боловсруулалт, хэрэглээ бага, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ахиц дэвшил гарахгүй байна. Сум хөгжүүлэх сангаас жил бүр тодорхой төслүүдийг дэмжиж, зээл олгодог ч үр дүн багатай байна.	Бусад, төсөл хөтөлбөр	Мал аж ахуйн үйлдвэрлэлд уламжлалт бүтээгдэхүүнийг, үйлдвэрлэдэг, хэрэглэдэг өрхийн тоог нэмэгдүүлж, нийт өрхийн 50-аас доошгүй хувьд хүргэж, сумын брэнд 2-с доошгүй бүтээгдэхүүнтэй болсон байна.	Засаг даргын Тамгын газар, баг, малчид

6.

1	2	3	4	5	6	7
		нөхцөлд оршин тогтнож чадах чадвартай төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, тэдгээрийг эдийн засаг болон эрх зүйн орчинд дэмжих				
19	Төсөл бичих сургалтад хамруулах	Төсөл бичих сургалтад зээл авах иргэд болон төсөл бичих сонирхолтой 30-аас доошгүй иргэнийг хамруулсан байна	2021 онд Бэст төвтэй хамтран 28 иргэнийг төсөл бичих сургалтад хамруулсан.	Бусад эх үүсвэр	30 иргэн сургалтад хамрагдаж 5-аас доошгүй иргэн зээл авсан байна.	Ажлын хэсэг
20	Сумд орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулж, нийтийн ахуйн үйлчилгээний үйл ажиллагааг сэргээн ажлын байр нэмэгдүүлэх, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	-Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсан байна. -Орон нутгийн өмчид бүртгэлтэй ашиглагдахгүй байгаа барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулна.	Ахуйн үйлчилгээний цогцолбор байдлаар ажиллаж байгаа үйлчилгээ байхгүй.	Бусад эх үүсвэр	Аж ахуйн нэгж байгуулагдаж, 10-с доошгүй ажлын байр бий болсон байна.	Ажлын хэсэг
21	Эко аялал зохион байгуулж эх нутгаараа бахархах үзлийг төлөвшүүлэх	-Иргэдийг орон нутгийнхаа түүх соёлын дурсгалт газар, байгалийн үзэсгэлэнт газар болон ургамал, ан амьтан бүхий газар нутгаар аялах маршрут тогтоосон байна. -Хүүхэд, залуучуудад эх түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлснээр	Хүүхдүүдийг хамруулан зохион байгуулж байсан ба цар тахлын улмаас хэрэгжээгүй.	Төсөв шаардлагагүй	Нутаг орныхоо байгаль амьтан ургамалтай танилцсанаар эх дэлхий, нутаг орноо хайрлах зөв хандлагатай иргэдийн тоо нэмэгдэнэ.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нар
22	Сумын ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэх, иргэдийн амрах орчинг сайжруулах	-Сумын төв доторх нийтийн эзэмшлийн гудамж талбайг зүлэгжүүлнэ. -Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд авто зам дагуу 10000 мод тарьж ургуулна. -Гудамж хорооллын өнгө үзэмжийг сайжруулна.	Өнгөрсөн онд 5000 гаруй модыг суулгасан	Орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт сайжирч ногоон байгууламжаар тэргүүлэгч сум болсон байна.	Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч